

**“ХӨВСГӨЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018-04-17

Мөрөн

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн хурлын зааланд 2018 оны 04-р сарын 17-ны өдрийн 14.00 цагт эхлэв.

Хурлын ирцийг “Хөвсгөл” ХКомпанийн ТУЗ-ийн дарга Л.Дашцэрэн 93.8 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

- Компанийн санхүүгийн тайлан
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- Компанийг өөрчлөн байгуулах төсөл
- Компанийн ТУЗ-ийг сонгох
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнэ
- ХХК-ийн дүрмийн төсөл
- Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмын төсөл

Гүйцэтгэх захирал Л.Тэгшбаяр - Компанийн санхүүгийн тайлан

- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.

ТУЗ-ийн дарга Л.Дашцэрэн - Хянан шалгах зөвлөлийн тайлан

- Компанийг өөрчлөн байгуулах төсөл
- Компанийн ТУЗ-ийг сонгох
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнэ
- ХХК-ийн дүрмийн төсөл
- Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмын төсөл танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Л.Дашцэрэн- Компанийг өөрчлөн байгуулах асуудлаар санал хураалт явуулж шийдвэрлэв.

Тооллогын комиссын дарга Л.Тэгшбаяр- Тооллогын комиссын дүнг танилцуулав.

ТУЗ-ийн дарга Л.Дашцэрэн- Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 15.30 минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТУЗ-ИЙН ДАРГА  Л.ДАШЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Ж.САЙНЖАРГАЛ